

Маргааны товч

Ховд аймгийн Засаг даргын 2023 оны А/410 дугаар захирамжаар Жаргалант сумын шинэ суурьшлын бүсэд газар эзэмшигч 13 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээг "... зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй, газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй" үндэслэлээр хүчингүй болгосны дотор "Мон лун хөгжил" ХХК багтжээ.

Нэхэмжлэгч талаас актыг эс зөвшөөрч "... газрын төлбөрийг банкаар цаг тухайд нь төлж байсан, 2019 онд хуульд өөрчлөлт орж, газрын төлбөрийн нэхэмжлэл системээр үүсэж, төлбөр төлөх болсон боловч манай компанид нэхэмжлэл үүсээгүй. Төлбөр төлөөгүй асуудал нь компанийн буруутай үйл ажиллагаа биш, Газрын албанаас нэхэмжлэл үүсгээгүй тохиолдолд компани төлөх боломжгүй, ... тухайн газраа ашиглаж эхлээд он болгонд тодорхой хэмжээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн, ... ковидын хорио цээрийн нөхцөл байдал барилгын баримт бичиг бүрдүүлэхэд нөлөөлсөн ..." гэж;

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс "... 2019 онд "Мон лун хөгжил" ХХК-д 15 га газрыг шинэчлэн олгосон боловч 5 жилийн хугацаанд ямар ч ажил хийгдээгүй, ... Засаг даргын захирамж нь хуульд нийцсэн, хуульд үндэслэж гарсан, захирамж гарахаас өмнө сонсох ажиллагаа явуулсан. Газрын татварын талаар бүртгүүлэх үүрэг нь тус компанид байгаа ..." гэх агуулгаар тус тус маргасан.